



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 37 (418)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим офицер, ахлагч нарыг медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- *Улс төрийн намын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2005 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны аравдугаар сарын 7

№37 (418)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|----------------------------------------------------|-----------|-----|
| 943. | Зарим офицер ахлагч нарыг
медалиар шагнах тухай | Дугаар 47 | 761 |
| 944. | Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний тухай | Дугаар 48 | 765 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|-------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|-----|
| 945. | Сангийн яамны үйл ажиллагааны стратеги,
зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн
хөтөлбөрийг зөвшөөрөх тухай | Дугаар 170 | 766 |
|------|-------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|-----|

Гурав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- | | | | |
|------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----|
| 946. | Улс төрийн намын тухай хуулийн зарим заалт
Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг
зөрчсөн эсэх тухай маргааныг хянан
шийдвэрлэсэн тухай | Дугаар 2/05 | 774 |
| 947. | Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн
хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 2/06 | 777 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 9 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

Зарим офицер, ахлагч нарыг медалиар шагнах тухай

Энхийг сахиулах хүмүүнлэгийн олон
улсын цэргийн ажиллагаанд оролцож, албан
үүргээ нэр төртэй биелүүлсэн Зэвсэгт

хүчний цэргийн багийн дор дурдсан
офицер, ахлагч нарыг медалиар
шагнасугай.

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Данзандоржийн Нарантулга-Зэвсэгт
хүчний жанжин штабын Энхийг сахиулах

ажиллагааны газрын удирдлага, төлөвлөлтийн
хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа

ЭНХИЙН ТӨЛӨӨ МЕДАЛИАР:

1. Мэндбаатарын Алтанбат-Зэвсэгт хүчний
013 дугаар ангийн станцын дарга, жолооч, ахлагч

2. Отгонбатын Ариунжаргал-Зэвсэгт
хүчний 150 дугаар ангийн буудагч, дэд ахлагч

3. Алтангэрэлийн Алтанхуяг-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
4. Гомбожавын Амартүвшин-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн холбооны техник хэрэгсэл хадгалах тасгийн дарга, дэслэгч
5. Батмөнхийн Амартүвшин-Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн салааны захирагч, ахлагч
6. Канадын Абай-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн тасгийн дарга, дэслэгч
7. Дамдинсүрэнгийн Ариунболд-Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн салааны захирагч, ахлагч
8. Сундуйн Алтанхуяг-Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн механик жолооч, ахлах ахлагч
9. Баатарын Алтанхүү-Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн механик-жолооч, дэд ахлагч
10. Бадамхорлоогийн Ариунбат-Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, дэд ахлагч
11. Орсоогийн Ариунболд-Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн оператор тасгийн оператор, дэслэгч
12. Ваанчигийн Анхболд-Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн станцын дарга, жолооч, дэд ахлагч
13. Түмэндэмбэрэлийн Амгаланбаатар-Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн механик, телефончин, дэд ахлагч
14. Цолмонгийн Алтанхүү-Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
15. Цумбагийн Буянжаргал-Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа
16. Сүхээгийн Баяр-Очир-Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн ХАА-н үйлдвэрлэл эрхэлсэн орлогч, хошууч
17. Шаравсамбын Батдаваа-ЗХЖШ-ын Ар талын газрын мэргэжилтэн, ахлах дэслэгч
18. Гальягийн Баатар-Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн галт хэрэгсэл, артиллерийн зэвсгийн нярав, ахлагч
19. Гантөмөрийн Бат-Эрдэнэ-Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн соёл хүмүүжлийн албаны дарга, ахлах дэслэгч
20. Баахүүгийн Бодьхүү-Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн инженер, ахлах дэслэгч
21. Хундагын Батбилэг-Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн химийн дарга, ахмад
22. Эрдэнэбатын Батзориг-Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн электроник инженер, дэслэгч
23. Очирдамбын Бүрэнбат-Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн кабельчин, дэд ахлагч
24. Даваацэрэнгийн Батсайхан-Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн ээлжийн дарга, инженер, ахлах дэслэгч
25. Моломнүрдэвийн Батбаатар-Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн станцын дарга, жолооч, дэд ахлагч
26. Пүрэвийн Батболд-Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн мэргэжилтэн, ахлагч
27. Аюушийн Батмөнх-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн тасгийн захирагч, ахлах ахлагч
28. Хэнчбишийн Болдбаатар-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн тасгийн пулемётчин, дэд ахлагч
29. Ганхуягийн Батхүрэл-Зэвсэгт хүчний жанжин штабын мэргэжилтэн, дэд хурандаа
30. Мижидийн Буянтогтох-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч
31. Дашнамжилын Батмөнх-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн ротын техникийн орлогч, дэслэгч
32. Жаргалтуяагийн Батзориг-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн пулемётчин, дэд ахлагч
33. Оргодолын Баттулга-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн механик-жолооч, дэд ахлагч
34. Хишигбадрахын Бямбадорж-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн механик-жолооч, дэд ахлагч
35. Мэндбаярын Батболд-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн инженер, ахлах дэслэгч
36. Мэндийн Батдорж-Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн тасгийн дарга, ахлах дэслэгч
37. Буянгийн Болд-Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн ээлжийн дарга, ахлах ахлагч
38. Сэрэээнгийн Батбаяр-Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн механик-жолооч, ахлагч
39. Должингийн Баяртогтох-Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн нярав-засварчин, ахлагч
40. Энхтайваны Бат-Эрдэнэ-Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн станцын дарга, ахлагч
41. Чинтогтохын Бат-Эрдэнэ-Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн химичин ариутгагч-жолооч, дэд ахлагч
42. Баатарын Батсайхан-Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн радиотелеграфчин, дэд ахлагч
43. Цэрэндоржийн Баярбат-Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн их эмч, дэслэгч



44. Бямбаагийн Батзолбоо-Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн мэс заслын их эмч, дэслэгч
45. Ишцогийн Бат-Эрдэнэ-Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч
46. Цэвэгдоржийн Билэгсайхан-Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн оператор, жолооч, ахлагч
47. Очирын Буяндалай-Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн станцын дарга, жолооч, дэд ахлагч
48. Болдбаатарын Булган-Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн тасгийн захирагч, ахлагч
49. Баасанхүүгийн Батбаяр-Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн жолооч, ахлагч
50. Хавдалын Батырбек-Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн салааны захирагч, ахлах дэслэгч
51. Гончигоогийн Батсүх-Зэвсэгт хүчний 029 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч
52. Дангаасүрэнгийн Бямба-Очир-Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн тагнуулын дарга, хошууч
53. Айзуусэдийн Гарамгайбаатар-ТЕГ-ын Хилийн 6 дугаар отрядын дэргэдэх тасгийн ахлах ажилтан, ахлах дэслэгч
54. Цогоогийн Ганхуяг-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн тасгийн пулемётчин, дэд ахлагч
55. Жаргалсайханы Ганбагана-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн засварчин, дэд ахлагч
56. Чилаажавын Галтбаяр-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургуулийн төвийн галын хотхоны дарга, ахлах ахлагч
57. Сангидоржийн Ганхуяг-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн авто тээврийн салааны жолооч, ахлах ахлагч
58. Самбуугийн Гантулга-Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн кино механикч- жолооч, дэд ахлагч
59. Чулуундоржийн Гантулга-Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн механик-жолооч, дэд ахлагч
60. Чилхаагийн Ганхуяг-Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн батареин захирагч, ахлах дэслэгч
61. Мягмарын Ганбаатар-Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн жолооч, ахлагч
62. Жамсрангийн Ганбаатар-Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн дивизионы захирагч, хошууч
63. Батчулууны Гантөмөр-Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
64. Намсрайн Гантөмөр-Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн батальон захирагчийн техникийн орлогч, ахмад
65. Гантэвшүүрийн Ганбат-Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн салааны захирагч, ахлах ахлагч
66. Орсоогийн Ганбаатар-Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн ротын захирагчийн техникийн орлогч, ахлах ахлагч
67. Баасанхүүгийн Ганхуяг-"Соёмбо" сонины жолооч, ахлагч
68. Лхагвасүрэнгийн Ганбат-Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн тасгийн захирагч, ахлах ахлагч
69. Бүтэнбаярын Ганзориг-Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
70. Гэлэгрэвжаагийн Гэлэгдорж-Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн зэвсгийн инженер, дэслэгч
71. Чулуунбатын Гантулга-Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн харуулчин, дэд ахлагч
72. Сосорбарамын Дашдондог-Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн ротын техникийн орлогч, ахлах дэслэгч
73. Баясгалангийн Даваа-Очир-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн салааны захирагч, ахлах дэслэгч
74. Мижиддоржийн Доржбаатар-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн оператор, дэд ахлагч
75. Гүндалайн Давхарбаяр-Зэвсэгт хүчний 189 дугаар ангийн жолооч, дэд ахлагч
76. Дагвасүмбэрэлийн Дашзэвэг-Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн ахлах оператор, ахмад
77. Дашийн Доржпалам-Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн авто тээврийн салааны захирагч, ахлах ахлагч
78. Пүрэв-Очирын Дамдинпүрэв-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
79. Сүрэнгийн Дэмбэрэлдагва-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч
80. Отгонбатын Жаргалсайхан-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн наводчик, оператор, дэд ахлагч
81. Дашзэвэгийн Зоригоо-Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч
82. Дэшигийн Золбаяр-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
83. Дамдиндоржийн Зоригт-Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн салааны захирагч, ахлах дэслэгч
84. Бузгайн Лхамсүрэн-Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч
85. Гаваагийн Лхагва-Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн салааны захирагч, ахлах ахлагч



86. Будын Лхагва-Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн нууцын хэрэг хөтлөгч, дэд ахлагч
87. Чимэдцэвэгийн Лутбаяр-Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн сургуулийн төвийн дарга, ахлах ахлагч
88. Жамбалын Молорболд-Зэвсэгт хүчний 189 дугаар ангийн программ хангамжийн төвийн дарга, хошууч
89. Юндэнгийн Мөнхбат-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
90. Нямдоржийн Мөнхбат-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн машины дарга, дэд ахлагч
91. Тогоогийн Мөнх-Эрдэнэ-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн зэвсгийн нярав, ахлагч
92. Хөх-Өвгөний Мөнхбат-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн тасгийн пулеметчин, дэд ахлагч
93. Мянганбуугийн Мөнхзул-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч
94. Баттогтохын Мөнхбат-Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн техникч-жолооч, ахлагч
95. Банзрагчийн Мөнхбаяр-Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн жолооч, цахилгаанчин, дэд ахлагч
96. Дашдондовын Мөнхбаатар-Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн артиллерийн хол хэмжигч, дэд ахлагч
97. Борхүүгийн Мөнхтуул-Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
98. Зэвэгийн Мягмархүү-Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн артиллерийн тооцоочин, дэд ахлагч
99. Нохойжавын Мягмардорж-Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч
100. Буянгийн Мэндбаяр-Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн дадлагын багш, дэд ахлагч
101. Зоноровын Мягмаржав-Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хүн эмнэлгийн байрны дарга, хошууч
102. Лхагвасүрэнгийн Мөнх-Эрдэнэ-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн соёл хүмүүжлийн зааварлагч, ахмад
103. Чулуундоржийн Мөнхдүүрэн-Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, дэд ахлагч
104. Батчулууны Мөнх-Оргил-Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн засварчин, жолооч, дэд ахлагч
105. Базаррагчаагийн Нарансүх-Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлгийн их эмч, дэслэгч
106. Адъяагийн Наранбаатар-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
107. Батжаргалын Отгонбаяр-Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагчийн орлогч, дэд хурандаа
108. Оюунбаатарын Оюунбат-Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн салааны захирагч, ахлах ахлагч
109. Ангаагийн Отгонбаатар-Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн химийн хадгалах тасгийн оператор, ахлагч
110. Энхболдын Одхүү-Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн зэвсгийн нярав, дэд ахлагч
111. Балданжамцын Отгонбаяр-Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн засварчин-нярав, ахлах ахлагч
112. Дамбийн Отгондаваа-Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн ашиглалтын албаны дарга, ахмад
113. Сүхбаатарын Одбаяр-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн наводчик, дэд ахлагч
114. Буян-Өлзийн Пүрэвдорж-Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
115. Лувсандоржийн Пүрэвдорж-Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн артиллерийн зэвсгийн засварчин, жолооч, ахлах ахлагч
116. Нарын Пүрэвдорж-ЗХЖШ-ын авто, хуягт техникийн хэлтсийн мэргэжилтэн, ахмад
117. Намсрайжавын Пүрэв-Очир-Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн станцын дарга, жолооч, дэд ахлагч
118. Даваагийн Содномцог-Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн артиллерийн дарга, хошууч
119. Бүлтүүшийн Сэргэлэн-Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн станцын дарга, жолооч, ахлагч
120. Басангийн Сэр-Од-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн гранатомётчин, дэд ахлагч
121. Должингийн Сараням-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн зенитийн салааны захирагчийн орлогч, дэд ахлагч
122. Доржпаламын Санжаа-Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн химичин-ариутгагч оператор, дэд ахлагч
123. Дамдинхандын Сүхбат-Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн механик жолооч сургагч, дэд ахлагч
124. Энэбишийн Сэрээтэр-Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн салааны захирагч, дэд ахлагч

125. Ганбаатарын Төмөр-Очир-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн пулемётчин, дэд ахлагч

126. Гүнсэнжавын Түмэн-Амгалан-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн химийн оператор, дэд ахлагч

127. Молсонгийн Тогтхаан-Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн тасгийн захирагч, тагнуулчин, ахлагч

128. Гантөмөрийн Төмөрчөдөр-Зэвсэгт хүчний 029 дүгээр ангийн засварын дарга, ахлах ахлагч

129. Уламбаярын Ууган-Эрдэнэ-Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн холбооны инженер, ахмад

130. Эрдэнэдэлгэрийн Уламбаяр-Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч

131. Батбаярын Намхайдорж-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн соёл хүмүүжлийн дарга, дэслэгч

132. Лхагвасүрэнгийн Хүчитбаатар-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн наводчик-оператор, дэд ахлагч

133. Өлзийн Хүрэлзэвсэг-Зэвсэгт хүчний 011 дугаар ангийн засварчин, дэд ахлагч

134. Жамъянгаравын Хүрэлбаатар-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн зэвсгийн дарга, дэд хурандаа

135. Батбаатарын Цолмон-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн наводчик-оператор, дэд ахлагч

136. Доржлаламын Цогтгэрэл-Зэвсэгт хүчний 016-р ангийн нярав засварчин, дэд ахлагч

137. Баасанжавын Цагаанбилэг-Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн гал сөнөөгч, дэд ахлагч

138. Ванчаагийн Цогбадрах-Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн салааны захирагч, ахлагч

139. Доржийн Чинбат-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн тоотын дарга, дэд ахлагч

140. Базарсадын Чулуунхүү-Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч

141. Бадамсэрээжидийн Чинзориг-Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн агаарын довтолгооноос хамгаалахын даргын туслах, ахлах дэслэгч

142. Базарсадын Эрдэнэпил-Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн дивизионы штабын дарга, ахмад

143. Даш-Очирын Эрдэнэ-Очир-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн явган цэргийн байдлааны машины дарга, дэд ахлагч

144. Цэрэнчимэдийн Энхболд-Зэвсэгт хүчний 019 дүгээр ангийн буудагч, дэд ахлагч

145. Батсуурийн Эрдэнэбаатар-Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн буудлагын талбайн оператор, дэд ахлагч

146. Цэрэнбатын Энхмэнд-Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн эксковаторчин-жолооч

147. Лхасүрэнгийн Энхбат-Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн ар талын даргын орлогч, албаны дарга, дэд хурандаа

148. Батсуурийн Эрдэнэчулуун-Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн тасгийн дарга-засварчин, ахлагч

149. Чойжилсүрэнгийн Эрдэнэбулган-Зэвсэгт хүчний 032 дүгээр ангийн зохицуулагч, дэд ахлагч

150. Гэмгүйн Ялалт-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн ротын захирагч, ахлах дэслэгч

151. Балжидын Баатар-Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн штабын даргын орлогч, хошууч

152. Тогтмолын Сүхбаатар-Зэвсэгт хүчний Клиникийн төв эмнэлгийн их эмч, ахлах дэслэгч

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 10 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 61 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Бирваагийн Мандахбилэгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилж, Балдангийн

Янжмааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний үүргээс чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 8 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай

Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны

стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2001 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 75 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

Ч.УЛААН

САНГИЙН САЙД

Н.АЛТАНХУЯГ

Засгийн газрын 2005 оны 170 дугаар тогтоолын хавсралт

САНГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Оршил

Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "Хөтөлбөр" гэх/-т Сангийн сайдын болон Засгийн газрын танхимын шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэсэн улс орны санхүү, эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлагаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ хийх, мэдээлэх, үр дүнгийн үнэлгээг зохион байгуулах, түүнчлэн нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн дотоод хяналт, худалдан авах ажиллагаа, зээл, тусламж, өрийн удирдлагын асуудлыг хамарсан Сангийн яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2 Үндэслэл

Хөтөлбөрийг Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын бүтцийн тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Сангийн яамны зохион байгуулалтын бүтцийг батлах тухай Засгийн газрын 2004 оны 242 дугаар тогтоолыг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Сангийн яамны үйл ажиллагааны үндсэн зарчим бол яамны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, хууль дээдлэх явдал мөн. Сангийн яам нь үйл ажиллагааныхаа үндсэн зарчимд тулгуурлан төрийн захиргааны төв байгууллагын зорилт, чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон энэхүү хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Засгийн газрын тухай хууль;
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль;
- Яамны эрх зүйн байдлын тухай хууль;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Нэгдсэн төсвийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль;
- Даатгалын тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Аудитын тухай хууль;
- Бусад хууль тогтоомж.

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын шилдэг туршлага, санхүү, эдийн засгийн салбарын

удирдлага, санхүүжилтийн шинэчлэлт, үйл ажиллагаа (бизнес)-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлт зэрэг арга зүйг хэрэглэв.

1.5. Удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн яамдын нэг болох Сангийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхэд эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалт, зээл, тусламж, бүртгэлийн хүрээнд үүрэг, хариуцлага хүлээж, Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд, Засгийн газрын Танхимд санхүү, эдийн засгийн чиглэлээр бүх талын зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлнэ. Сангийн яам нь санхүү, эдийн засгийн стратегийн бодлого, нэгдсэн төлөвлөлт болон хөгжлийн бодлого, төсвийн хуваарилалт, зарцуулалтын тэнцвэртэй байдал, харилцан уялдаа

холбоог хангах асуудалд өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.

Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх удирдлагын ерөнхий чиг үүргийн яамдын нэг болох Сангийн яам нь Засгийн газрын санхүү, эдийн засгийн зөвлөхийн үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Сангийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм.

Сангийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамаарагдана:

САНГИЙН ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Сангийн яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Сангийн сайд, Засгийн газрын Танхим байна. Сангийн яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон талын харилцааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохицуулахад чиглэгдэнэ.

Сангийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоож, тус яамны зохион байгуулалтын

бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

Хоёр. САНГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар
Сангийн яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Сангийн

сайдын эрхлэх ажлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Сангийн сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө өгөх, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Сангийн яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1. улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги, үндсэн чиглэл, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээгээр цаг тухайд нь хангах, Сангийн сайд, Засгийн газрын Танхимд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;

2.2.2. Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засаг, санхүүгийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд бусад яам, газруудын үйл ажиллагааны уялдааг хангах, эдийн засаг, санхүүгийн удирдлага, төлөвлөлт, зохицуулалтад шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээгээр цаг тухайд нь хангах;

2.2.3. Эдийн засаг, санхүү, төсвийн удирдлагын чадавхийг бэхжүүлж, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах;

2.2.4. эдийн засгийн шинэчлэл, зохицуулалт, бүтцийн өөрчлөлтийн нэгдсэн бодлого явуулах, эдийн засаг, нийгмийн салбарын болон салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн уялдааг хангах бодлого боловсруулах;

2.2.5. улс орны хөгжлийн ерөнхий чиг хандлага, стратегитай уялдуулсан төсөв, санхүү, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах;

2.2.6. зээл, тусламжийн талаархи нэгдсэн бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох, гадаад, дотоод өрийн удирдлагыг бэхжүүлэх, хяналтыг чангатгах;

2.2.7. нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн дотоод хяналтын нэгдсэн бодлого, удирдлагаар хангах;

2.2.8. Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, удирдлага, зохицуулалтыг сайжруулах;

2.2.9. яамны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх.

2.3. Байгууллагын алсын хараа

Сангийн яам нь Монгол Улсын эдийн засгийг тогтвортой хөгжүүлж, иргэдийнхээ амьжиргааны түвшинг тасралтгүй дээшлүүлэхийн төлөө ажиллана.

2.4. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Сангийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь:

Монгол Улсын иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн, оновчтой удирдлагаар хангахад оршино.

2.5. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Сангийн яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

2.5.1. Санхүү, эдийн засгийн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;

2.5.2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

2.5.3. Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

2.5.4. Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, мэдээлэх, үнэлгээ өгөх.

2.6. Үйл ажиллагааны гол зорилт

Сангийн яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

2.6.1 Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:



2.6.1.1. улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, үндсэн чиглэл боловсруулахад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

2.6.1.2. макро эдийн засгийн үндсэн тэнцвэрт харьцааг хангахад зөвлөгөө өгөх;

2.6.1.3. эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, хөрөнгө оруулалтын болон төрийн өмчийн бодлого боловсруулахад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

2.6.1.4. төсөв, санхүү, татвар, гааль, даатгал, зээл, тусламжийн бодлого боловсруулахад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

2.6.1.5. зах зээлийн харилцааны зарчимд нийцсэн нягтлан бодох бүртгэл, аудитын бодлого боловсруулахад зөвлөгөө өгөх;

2.6.1.6. Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлогыг боловсруулахад зөвлөгөө өгөх.

2.6.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.6.2.1. төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, яамны удирдлага, албан хаагчдад дотоод ажил хэргийн дэмжлэг үзүүлэх;

2.6.2.2. Хүний нөөцийг зохистой ашиглах, чадавхийг сайжруулахад зөвлөгөө өгөх, нийтлэг үйлчилгээ үзүүлэх;

2.6.2.3. Сангийн сайдаас шийдвэр боловсруулан гаргахад эрх зүйн болон бусад дэмжлэг үзүүлэх;

2.6.2.4. яамны үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгох.

2.6.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.6.3.1. улсын төсвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

2.6.3.2. зээл, тусламж, өрийн удирдлагыг хэрэгжүүлэх;

2.6.3.3. Засгийн газрын мөнгөн хөрөнгийн удирдлага, зохицуулалтаар хангах, төрийн сангийн үйлчилгээ үзүүлэх;

2.6.3.4. санхүүгийн зах зээлийн болон салбар хоорондын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах;

2.6.3.5. нягтлан бодох бүртгэл, аудитын нэгдсэн тогтолцооны арга зүй, хяналтаар хангах;

2.6.3.6. Засгийн газрын худалдан авах ажиллагааны хяналт, зохицуулалтаар хангах.

2.6.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.4.1. сайдаас яам, агентлагийн төсвийн ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийн байдалд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;

2.6.4.2. эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх;

2.6.4.3. Салбарын хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх;

2.6.4.4. төсвийн ерөнхийлөн захирагч нарын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, үр дүнд үнэлгээ өгөх;

2.6.4.5. Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээний ашиглалтыг эрхлэх, дотоод мэдээллийн сүлжээ, сан бүрдүүлэх, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;

2.6.4.6. Сангийн сайдын эрхлэх ажлын хүрээний бодлого, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллээр үйлчлэх, яамны нээлттэй байдлыг хангах.

2.7. Үйл ажиллагааны зорилт


Сангийн яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.8. Үйл ажиллагааны стратегийн загвар

Сангийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:



Сангийн яамны үйл ажиллагааны стратегийн загвар (бизнес төлөвлөгөө)



2.9. Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө

Сангийн яамны эрхэм зорилго, чиг үүрэг, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулан баталж ажиллана. Сангийн яамны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь төсвийн ерөнхийлөн захирагч (Сангийн сайд)-зас төсвийн ерөнхий менежер (Төрийн нарийн бичгийн дарга)-тэй байгуулах үр дүнгийн гэрээний салшгүй хэсэг байна.

Гурав. САНГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Сангийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтална:

3.1.1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай яамны стратегийн зорилтыг уялдуулсан байх зарчим (яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

3.1.2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүдийн нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх);

3.1.3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын

үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал, яамны зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

3.1.4. Бүтэц энгийн байх зарчим (яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн буюу хоёроос дээшгүй шат дамжлагатай байх);

3.1.5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (яамны үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар, шуурхай удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх);

3.1.6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (яамны төрийн захиргааны албан хаагч нь Сайд, Засгийн газар (Танхим), бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлдөв автахгүй, төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг, үйлчилгээ үзүүлдэг байх);

3.1.7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Бүтцийн ерөнхий тогтолцооны зарчим болон үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо дор дурдсан загвартай байна:

САНГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



3.3. Зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг

Сангийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас дор дурдсан чиг үүрэг бүхий зохион байгуулалтын бүтцийн нэгж урган гарч байна:

1. Стратегийн удирдлага, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Эдгээр нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Сангийн сайдын эрхлэх ажлын хүрээний улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлоход чиглэгдсэн дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

-Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, хэтийн бодлого боловсруулах, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлогыг тодорхойлох;

-макро эдийн засгийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, биелэлтийг нэгтгэн дүгнэх, эдийн засаг, нийгмийн салбарын болон бус нутаг, салбар хоорондын хөгжлийн бодлогыг уялдуулах, макро эдийн засгийн үндсэн тэнцвэрт харьцааг хангахад зөвлөгөө өгөх, эдийн засаг, нийгмийн хүрээний салбарын өөрчлөлтийн бодлогыг тодорхойлох;

-эдийн засгийн макро түвшинд уялдуулсан төсөв, хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээлийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, улсын нэгдсэн төсвийн жилийн болон дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах;

-зээл, тусламж, өрийн бодлого болон олон улсын банк, санхүүгийн байгууллагатай харилцахад баримтлах зарчмыг тодорхойлох;

-зах зээлийн харилцааны зарчимд нийцсэн нягтлан бодох бүртгэл, аудит, хөрөнгийн үнэлгээний нэгдсэн бодлого, арга зүйг тодорхойлох;

-Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлогыг олон улсын нийтлэг жишиг, өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулах зэрэг болно.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Сангийн сайд, Засгийн газрын Танхимын эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэх бөгөөд эдгээр нь Сангийн сайд, Засгийн газрын танхимаас улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, Сангийн сайдыг мэргэшлийн өндөр, цаг үеэ олсон бодлогын зөвлөгөө, бүх талын шаардлагатай мэдээлэл, мэргэжлийн туслалцаа, дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Сангийн сайд, Засгийн газрын Танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яамд, Засгийн газрын

тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, олон улсын болон гадаад орны байгууллагууд байх болно.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол банк, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд яамны төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийг зохиистой ашиглах, чадавхийг сайжруулах, түүнчлэн удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, ажлын төлөвлөлт, тайлагналт, хариуцлагын тогтолцоог хөгжүүлэх, Сангийн сайд, захиргааны удирдлагад дотоод ажил хэргийн болон хууль зүйн зөвлөгөө, эрх зүйн туслалцаа үзүүлэх үндсэн үүргийг хүлээж, эдийн засаг, санхүүгийн холбогдолтой хууль эрх зүйн баримт бичгийг боловсруулах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах, Сангийн сайдын дангаар буюу бусад яам, газруудтай хамтран хууль тогтоомж, тогтоол шийдвэр, нийтээр дагаж мөрдүүлэх дүрэм, журам, зааврын төсөл боловсруулах ажилд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, дээд байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явц, байдалд хяналт тавих, гүйцэтгэлийг хангуулах, шинээр гарсан хууль тогтоомжид салбарын эрх зүйн баримт бичиг нийцэж байгаа эсэхийг хянаж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, гадаад, дотоодын байгууллага, хуулийн этгээдтэй байгуулах гэрээ, хэлэлцээрийн төсөлд хууль зүйн зөвлөгөө өгөх, салбарын хууль тогтоомжийн бүртгэл, лавламжийн сан бүрдүүлж, түүнийг байнга баяжуулж байх, захиргаа, санхүү, аж ахуйн ажлыг зохицуулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн, жигд ажиллагааг хангахад чиглэнэ. Энэ нь Сангийн сайдаас санхүү, эдийн засгийн холбогдолтой шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд хууль зүйн зөвлөгөө, эрх зүйн туслалцаа болон дотоод ажлын үйлчилгээ үзүүлэх, яамны газар, хэлтэс хоорондын ажлын уялдааг хангах, төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, архив, албан хэргийн хөтөлөлт, иргэдийн өргөдөл, гомдлын барагдуулалтад хяналт тавих, хөдөлмөрийн сахилга, дотоод дэг журмыг чанд сахиулах, ажил хэрэгч шуурхай байдлыг хангах, дотоод хяналт шалгалтыг чангатгах, аппаратын удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, албан хаагчдын ажлын байрны ахуй нөхцөл, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамж, үйлчилгээг сайжруулах, улмаар санхүү, эдийн засгийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний нийтийн



баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Сангийн сайд, Сангийн дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, төсөв, санхүү, татвар, гааль, хяналт шалгалт, нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн удирдлага байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам болон бусад яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллагууд байх болно.

3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Эдгээр нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлогын хэрэгжилтийг зохицуулахтай холбогдсон дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

-улс орны эдийн засгийн болон төсөв, санхүү, татвар, гааль, мөнгө зээл, хөрөнгө оруулалт, төрийн өмчийн бодлогын хэрэгжилтийг зохицуулахтай холбогдсон зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, хөгжлийн төлөв байдлыг үнэлэх;

-салбар хоорондын болон бус нутгийн хэмжээний бүтцийн өөрчлөлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах, эдийн засаг, нийгмийн салбарын болон салбар хоорондын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах, улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавих, банк, санхүүгийн салбарын нийтлэг асуудлыг уялдуулан зохицуулах;

-улсын төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах, төсвийн тэнцлийг хангах, төсвийн алдагдал нөхөх эх үүсвэрийг тогтоох, улс орны санхүүгийн нөөцийг гадаад, дотоод эх үүсвэрээс бүрдүүлэх, түүний оновчтой зөв хуваарилалтыг зохицуулах;

-Засгийн газрын мөнгөн хөрөнгийн төлөвлөлт явуулах, дансуудыг хөтлөх, тэдгээрийн урсгал зарцуулалтад хяналт тавих, төсвийн гүйцэтгэлийн тайланг хүлээн авах, төсвийн нэгдсэн тайлан гаргах, төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн ажлыг удирдлагаар хангах;

-Засгийн газрын зээллэг, үнэт цаас гаргах, түүний хэрэгцээг тогтоох, арилжааг зохион байгуулах, Засгийн газрын зээлийн баталгаа гаргах, өрийн удирдлагын хэрэгжилтийг зохицуулах;

-Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн арга зүйг боловсруулах, аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэлийн стандарт нэвтрүүлэх, нягтлан бодох бүртгэлийн арга зүйн

зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, тайлан тэнцлийн маягт, аргачлалыг боловсруулах, аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан тэнцлийн нэгдсэн үзүүлэлтийг гаргах;

-гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын хамтын ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах, зээл, тусламжийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг уялдуулан зохицуулах;

-төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, сурталчлах, сургалт зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгөх, судалгаа шинжилгээ хийх, тайлагнах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэг чиг үүргийг гүйцэтгэнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Монгол Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтийг хангах, төсвийн зарлагын оновчтой бүтцийг бүрдүүлэх, төсвийн тэнцэл, Засгийн газрын дансын хөрөнгийн урсгал зарцуулалтыг хангах, улмаар төсвийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын тайлан, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргуулах замаар төсвийн хөрөнгийг үр ашигтай ашиглах, гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах, түүнчлэн зээл, тусламжаар санхүүжүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулахтай холбогдсон шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, Сангийн сайдыг өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, бүх талын шаардлагатай мэдээлэл, мэргэжлийн тусалцаа, дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Сангийн сайд, Засгийн газрын Тэнхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, бусад хэрэглэгчид байх болно.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол банк, Төрийн өмчийн хороо байна.

4. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Эдгээр нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд Сангийн сайдын эрхлэх ажлын хүрээний бодлого, үйл ажиллагааны хэвлэл мэдээллийн сурталчилгаа явуулах, яамны ажлын хэвийн үйл ажиллагааг хангахуйц дотоод мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах, мэдээллийн технологийн шилдэг орчин бүрдүүлэх, Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээний ашиглалтыг эрхлэх, дотоод мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн технологийн үйлчилгээг үзүүлэх,



түүнчлэн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, Сангийн сайдаас яам, агентлагийн менежерүүдтэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, улмаар санхүү, эдийн засгийн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн болон хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, төсвийн ерөнхийлөн захирагч нарын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланд дүн шижилгээ хийх, дүгнэлт гаргах, үнэлгээ өгөх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Эдгээр нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, үйл ажиллагааны үр дүнд дээшлүүлэхэд чиглэнэ.

Эдгээр нь Сангийн сайд, Сангийн дэд сайд,

яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгж, харьяа агентлагт бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг сайжруулахтай холбогдсон мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх, цаг үеийн шаардлагатай мэдээллээр хангах замаар хэрэгжинэ.

Эдгээр нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Сангийн сайд, Сангийн дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд. Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яамд, аж ахуйн нэгж, байгууллагууд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар, аймаг, нийслэлийн Төрийн сан байх болно.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 2/06

Улаанбаатар хот

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗААЛТЫГ ЗӨРЧСӨН ЭСЭХ ТУХАЙ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим
13.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Н.Жанцан, Ж.Болдбаатар /илтгэгч/, П.Очирбат, Ч.Дашням нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Баянгол дүүргийн 12 дугаар хороо, 27 дугаар байр, 16 тоотод оршин суугч, иргэн Х.Сэлэнгэ, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Д.Одбаяр, Д.Ганхуяг нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар Улс төрийн намын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 12 дугаар хороо, 27 дугаар байр, 16 тоотод оршин суугч, иргэн Х.Сэлэнгэ Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

1. Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3-д "Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан, түүнчлэн нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглоно" гэж заасан нь Үндсэн

хуулийн эрх зүйн онолын үүднээс авч үзвэл, хүн хэрвээ өөрийн үзэл бодлын үүднээс эвлэлдэн нэгдсэн нам нь үйл ажиллагаагаа зогсоосон /дахин тухайн үзлийг нийгэмд хэрэгжүүлэхгүй нь/, эс бөгөөс өөр бусад намтай нийлэн нэгдэж өөрчлөн байгуулагдсан /өөрчлөгдсөн гэдэг нь мөн үзэл санаанд өөрчлөлт гарсан байх нь/, түүнийг тараасан /анх нам байгуулагдахдаа шударга ёс, хуулийн дагуу байсан учраас мэдээж Дээд шүүх бүртгэсэн боловч үзэл санаанаасаа гажиж, улмаар хууль зөрчсөнөөр Дээд шүүх тарвах шийдвэр гаргасан/ тохиолдолд дахин эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх эрхтэй бөгөөд өөрийн үзэл санааны үндсэнд эвлэлдэн нэгдэж байсан намынхаа нэрийг дахин хэрэглэх эрхтэй юм. Нөгөө талаар намын нэр нь үзэл санааны хураангуйлсан хэлбэр бөгөөд үзэл санааны үндсэнд эвлэлдэн нэгдсэн намын гишүүдийн оюуны өмч учраас төр намын асуудалд хөндлөнгөөс оролцож, энэхүү эрхэнд халдаж, цаг хугацааны хязгаарлалт хийж байгаа нь эвлэлдэн нэгдэх эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэх боломжийг хааж байна.

Мөн төр намын хэрэгт оролцон, түүний дотоод асуудлыг хуульчилж, улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсгийн "нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам: олон нийтийн бусад байгууллага

байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй", Араван зургадугаар зүйлийн 16-ын "итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх ...эрх чөлөөтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна. Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3-ыг шинжлэн судалбал, нам үзэл санаа, үйл ажиллагаагаа зогсоосон, эсвэл бусад намтай нэгдэх замаар үзэл санаа үйл ажиллагааны хувьд өөрчлөн байгуулагдсан, эсвэл үзэл санаанаасаа ухарч хууль зөрчсөний улмаас Дээд шүүх намыг тараасан тохиолдолд, Монгол Улсын иргэн "нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, итгэл үнэмшил, үзэл бодлын үүднээс нам байгуулан, сайн дураараа эвлэлдэн нэгдэж", дахин өөрийн намын бүтэн болон товччилсон нэрийг хэрэглэх эрхгүй болсон байна. Намын нэр гэдэг нь намын гишүүдийн үзэл санааны илрэл, тэдний оюуны өмч учраас Дээд шүүхийн Тавдугаар зүйлийн 2-д заасан "Төр нь ...өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" гэсэн энэхүү заалтыг мөн зөрчиж, намын асуудалд хөндлөнгөөс оролцож, тэдний эрхийг хязгаарласан байна.

Ийнхүү хүний итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласнаар Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2-д заасан "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ", Аравдугаар зүйлийн 3-д заасан "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Улс төрийн намуудын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6-д "Нам үүсэн байгуулагдаж, Улсын Дээд шүүхэд бүртгүүлснээс хойш 18 сарын дараа Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож болох бөгөөд энэ заалт өөрчлөн байгуулагдаж, шинээр бүртгүүлсэн намуудад хамаарахгүй" гэж заасан нь хүн бүр тайван замаар, сайн дурын үндсэн дээр, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхээс гадна сонгуулийн тэгш эрхийн үндсэн дээр сонгох, сонгогдох тэгш эрхтэй бөгөөд энэхүү эрхээ эдлэхэд цаг хугацаа, орон зай, нутаг дэвсгэр, илэрхийлэх арга, хэлбэрийн хувьд төр хязгаарлалт хийх ёсгүй. Хэрвээ хязгаарлалт хийвэл ардчилсан ёс, үндсэн хууль ёсноос ухарч буй хэрэг болно. Хүний эрхийг хүлээн зөвшөөрч байгаа бол энэхүү эрхээ хэрэгжүүлэхэд эрх зүйн бус хязгаарлалт хийж болохгүй юм.

Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6-д заасан иргэд нам үүсэн байгуулж, Улсын Дээд шүүхэд бүртгүүлснээс хойш 18 сарын дараа Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох эрхтэй байгаа Үндсэн хуулийн Араван зургадугаар зүйлийн 9-д "Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй", 10 дугаар зүйлд "нийгмийн болон өөрсдийн ашиг

сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй" гэсэн заалтыг зөрчихөөс гадна тэгш эрхийн зарчмыг зөрчсөн байна.

Ийнхүү хүн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх эрхийн үндсэн дээр нэгдэн нам байгуулан, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарласнаар Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2-д заасан "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ", 10 дугаар зүйлийн 3-д заасан "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэсэн заалтуудыг мөн зөрчсөн байна" гэжээ.

Мөн иргэн Х.Сэлэнгэ өргөдөлдөө Улс төрийн намын тухай хуулийн дээрх заалтууд нь Монгол Улсын Үндсэн хууль төдийгүй Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын холбогдох заалтууд зөрчигдсэн талаар дурджээ.

Хоёр. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Одбаяр, Д.Ганхуяг нар 2005 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн талбартаа:

1. Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Нам оноосон нэртэй байх"-аар заахдаа намын нэр нь түүний үзэл санааны хураангуй байхаар тогтоогоогүй юм. Намын нэр бусад намын нэртэй адил байхыг хуулиар хориглосон. Нөгөө талаар барууны эсхүл зүүний үзэл баримтлалтай нэг чиглэлийн намууд байлаа ч адил нэртэй байх боломжгүй билээ. Иймд намын нэр үзэл санааны хураангуй байх ёстой гэх, түүнчлэн намын нэрээс шалтгаалан эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэх боломжийг хаасан гэх үндэслэлгүй болно.

Монгол Улсын иргэнд "нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөтэй байх зэрэг иргэний эрхийг Монголын төр Үндсэн хууль болон бусад хуулиаар заан эрх зүйн зохицуулалттай болгож баталгаажуулж өгсөн. Нөгөө талаар ямар ч хязгаарлалтгүй эрх хэмжээ, абсолют эрх гэж байдаггүй, байх ч боломжгүй, аливаа эрхийг тодорхой эрх зүйн зохицуулалтын хүрээнд эдлэх тухай ардчилсан зарчим олон улсын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг бөгөөд энэ хязгаар, зохицуулалтыг Үндсэн хуульд нийцсэн хуулийн зохицуулалтаар тогтоодог. Энэ ч үндэслэлээр Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалт, тухайлбал, Аравдугаар зүйлийн 2-т заасан

"Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ", мөн зүйлийн 3-т заасан "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ", Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

Улс төрийн нам нь хуулийн этгээд болохын хувьд түүнтэй холбогдсон зарим харилцааг холбогдох бусад хуультай, тухайлбал, Монгол Улсын Иргэний хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудтай нийцүүлэх, уялдуулах шаардлага бодитойгоор байсан юм. Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д хуулийн этгээд өөрийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг тусгасан нэртэй байх, 27.3-т хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй" байх, 27.4-т хуулийн этгээдийн нэрийг бусад этгээд хууль бусаар ашиглахыг хориглох, 27.5-д хуулийн этгээд нэрээ хуульд заасан /Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай/ журмын дагуу бүртгүүлж байхаар тус тус заасантай бүрэн нийцүүлж баталсан юм.

Тиймээс 6.3 дахь хэсгийн заалт нь сайн дураараа эвлэлдэн нэгдэх, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг эрхийг хязгаарлаж байгаа асуудал биш гагцхүү "хуулийн этгээд" болохын хувьд Иргэний хуулийн дээрх ерөнхий нөхцөлтэй нийцүүлсэн намын нэртэй холбогдсон эрх зүйн харилцааны зохицуулалт юм. Түүнчлэн гадаад улс орны, тухайлбал ардчилалд шинээр нэгдсэн орнуудын энэ төрлийн хуулиар намын нэрийг тусгайлан зүйл, заалт болгон тусгаж зохицуулсан жишгийг ч харгалзан үзсэн хэрэг.

Тухайлбал ОХУ, Украин, Беларусь, Казахстан зэрэг улсын Улс төрийн намын тухай хуульд намын нэртэй холбогдсон тодорхой хязгаарлалтууд тусгагдсан байна. ОХУ, Беларусьт шүүхээр татан буугдсан намын нэрийг дахин хэрэглэхийг бүр мөсөн хориглосон байна. Харин Монгол улсын Улс төрийн намын тухай хуулийн холбогдох заалтад "24" жилийн хугацаанд л хязгаарлаж байгаа юм.

2. Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн заалт нь Монголын улс төрийн тогтолцооны өнөөгийн төлөвшил, иргэд, улс төрчдийн улс төрийн мэдлэг боловсрол, соёлын түвшинтэй холбогдож зайлшгүй шаардлагаар урган гарсан зохицуулалт болно. Манай орны улс төрийн амьдралын өнгөрсөн арав гаруй жилийн практикаас үзэхэд иргэд нь жинхэнэ өөрсдийн улс төрийн үзэл бодол, ашиг сонирхлоороо эвлэлдэн нэгдэх, түүндээ итгэл үнэмшилтэй, тууштай байж, улс төрийн амьдралд идэвхтэй байнга оролцож, улс төрийн үзэл бодол, намын зорилт, зорилгоо бодитойгоор хэрэгжүүлж, тогтвортой ажиллахын тулд бус гагцхүү тухайн сонгуульд нэрээ дэвшүүлж оролцох гэсэн хэн нэгэн буюу цөөн хэдэн хүмүүс

өөрсдийн ашиг сонирхлын үүднээс бусдын тодорхой нэгэн хараат байдал /сургуулийнхаа суралцагсад, үйлдвэр, компанийхаа ажилтнаа/-ыг ашиглан, тэдний улс төрийн үзэл бодол, ашиг сонирхол, итгэл үнэмшлийг үл харгалзан нэрийн жагсаалт үйлдэж нам байгуулдаг, тэр нь цаашдаа дараа дараагийн сонгуульд оролцох зэргээр тогтвортой үйл ажиллагаа явуулах сонирхол, зорилгогүй байдаг нь харагдаж байгаа юм.

Энэ нь 1990 онд Улс төрийн намуудын тухай хууль батлагдсанаас хойш 20 гаруй нам улсын бүртгэлд бүртгэгдсэн боловч ихэнх намын байршил, хаяг, утас нь тодорхойгүй, удирдлага нь ч олдохгүй, үйл ажиллагаа нь ч тодорхойгүй, зарим нь бүр ор нэрийн төдий байгаагаар нотлогдож байгаа юм.

Бүртгэлийн байгууллага ч тэр бүр хяналт тавьж чадахгүй, хариуцлага тооцох механизм ч байхгүй байдал үргэлжилсээр байгаа юм. Энэ байдал нь тухайн намын гишүүдийн эрх ашгийг хөсөрдүүлж байгаа хэрэг гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Бий болсон энэхүү нөхцөл байдлыг арилгах, намуудын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, тэдгээрийн төлөвшилийн байдлыг харгалзан үзэж энэ заалтыг 1 жил 6 сарын хугацаагаар тусгасан. Гэхдээ энэ нь нам сонгуульд оролцох эрхийн асуудлыг анх удаа зохицуулж байгаа хэрэг биш гэдгийг анхаарах хэрэгтэй юм. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар "Сонгууль зарлахаас өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн нам буюу намуудын эрхтэй Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй" байхаар хязгаарлалт тогтоосон байдлыг дурдахад хангалттай юм.

Дээрх үндэслэлүүдээр Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9, 10 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй, түүнчлэн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна" гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан, түүнчлэн нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглосон хязгаарлалт хийсэн нь иргэдийн нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх үндсэн эрхэд халдсан шинжийг агуулжээ.

2. Аливаа нам үүсэн байгуулагдаж Улсын Дээд шүүхэд бүртгүүлснээр үйл ажиллагаа явуулах бүрэн эрхтэй байхад түүнийг 18 сарын дараа төрийн сонгуульд оролцуулахаар хуульчилсан нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хязгаарласан байна.

3. Улс төрийн намын тухай хуулийн дээрх заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3; Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

4. Өргөдөл гаргагч Х.Сэлэнгэ Цэцийн дунд суудлын хуралдааны явцад Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэсэн өргөдлийн шаардлагаасаа татгалзсан болно.

Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон

ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан, түүнчлэн нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглоно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсгийн "Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "Нам үүсэн байгуулагдаж Улсын Дээд шүүхэд

бүртгүүлснээс хойш 18 сарын дараа Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож болно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсгийн "Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3, 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3; Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

4. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3, 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтыг 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлэхээр тогтоосугай.

5. Энэхүү дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

ГИШҮҮД

**Н.ЖАНЦАН
П.ОЧИРБАТ
Ж.БОЛДБААТАР
Ч.ДАШНЯМ**

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2005 оны 9 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 2/07

Улаанбаатар
хот

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗААЛТЫГ ЗӨРЧСӨН ЭСЭХ ТУХАЙ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим
16.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Н.Жанцан /илтгэгч/, Л.Рэнчин, Ж.Амарсанаа, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, 15 дугаар хороолол, 28-1 тоотод оршин суугч, иргэн Х.Тэмүүжин, Нийслэлийн Баянгол дүүргийн 17 дугаар хороо, 1-13 тоотод оршин суугч, иргэн Б.Баяраа, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж, Э.Бат-Үүл нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, 15 дугаар хороолол, 28-1 тоотод оршин суугч, иргэн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд 2005 оны 8 дугаар сарын 29-ний өдөр гаргасан өргөдөлдөө:

"1. Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн "...намын бүлэгт зөвхөн тухайн намаас нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн орно" гэсэн заалт нь эрх зүйн нэг статустай, нэг төрлийн харилцааг зохицуулж байгаа

Улсын Их Хурлын тухай хуулийн хүчин төгөлдөр үйлчилж буй бусад заалт, үүнд: Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2-т заасан "Улсын Их Хуралд 8-аас доош суудал эзэлсэн хэд хэдэн намыг төлөөлж байгаа гишүүд... аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэх бол тухайн нам, эвслийн бүлэгт нэгдэн орох хүсэлтээ тавина", мөн зүйлийн 3-т заасан "Аль нэг намын бүлгийн гишүүн уг нам, эвслийн бүлгийн харъяаллаас татгалзсан тохиолдолд нам, эвслийн бүлгээс албан ёсоор гарч өөр бүлэгт нэгдэн орж болно", мөн зүйлийн 4-т заасан нэрээ бие даан дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох тухай заалтуудтай зөрчилдөж, хуульд зэрэгцсэн зөрчилдөөнтэй зохицуулалтыг бий болгож, улмаар Үндсэн хуулийн 1.2-т заасан "Хууль дээдлэх ёс нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчиж байна.

Мөн энэхүү заалт нь Улсын Их Хурлын гишүүдийн дунд эрх зүйн ялгаварлал бий болгож тодорхой зарим гишүүд, тухайлбал 8-аас дээш суудал бүхий намын Улсын Их Хуралд сонгогдсон гишүүний "бүлгийн харъяаллаас татгалзан гарч өөр бүлэгт нэгдэн орж болох", бие даан нэр дэвшиж сонгогдсон гишүүний "аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох" зэрэг эрхээ эдлэх боломжгүйд хүрч Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...тэгш байдал .. нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын "Аль нэг нам ...ын гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно" гэснийг зөрчиж байна.

Өөрөөр хэлбэл Улсын Их Хуралд 8-аас доош суудал бүхий нам, 8-аас дээш суудал бүхий нам, бие даан нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд шударга ёсны өөр өөрийн тодорхой онцлогтой аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэн орох, гарах хүсэлт тавих, нөгөө талаас нам эвслийн бүлгүүд тухайн гишүүний хүсэлтийг хүлээн авч өөрийн бүлэгт нэгтгэх эсэхээ улс төр, хууль зүйн шахалт, хавчилтгүйгээр хэлцэн шийдэх нь чөлөөт ардчилсан парламент дахь зүй ёсны асуудал бөгөөд энэхүү зүй ёсны байдал Улсын Их Хурлын тодорхой нэг бүлэг, тодорхой хэсэг гишүүдэд хамааралгүй болж, хуулиар хязгаарлагдсан нь Үндсэн хуулийн 1.2-т заасан "Ардчилсан ёс, шударга ёс ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчиж байна.

2. Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулсан хуулийн үйлчлэлийг тодорхойлсон "Энэ хууль Улсын Их Хурлын 2004 оны 4 дэх удаагийн ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд үйлчилнэ" гэсэн заалт нь Үндсэн хуулийн хууль дээдлэх ёсны зарчимд үндэслэдэг "хууль нийтлэг ноёрхлоор тодорхойлогдсон байх ёстой бөгөөд тодорхой нэг субъект, тодорхой нэг тохиолдолд зориулагдах ёсгүй" гэсэн эрх зүйт төрийн суурь зарчим, Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дээрх заалтыг зөрчиж байна.

Тодорхой хуулийн хүрээнд сонгуульд эвсэл байгуулж оролцоод сүүлд нь өөрсдөөдөө зориулсан хууль гаргаж мөрдүүлэх нь ардчиллын ёс зүйд нийцэхгүй, Үндсэн хууль бусад хуулийн дагуу Улсын Их Хурлын үйл ажиллагаагаа явуулах, хуулийн бусад заалтууд хэвийн үйлчлэхэд сөрөг нөлөөтэй, ээлжит сонгуулиар сонгогчдын өгсөн саналыг үл хүндэтгэсэн, улс төрийн намуудын хариуцлагыг сулруулсан хууль болсон байна. Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлаас 2005 оны 8 дугаар сарын 4-ний өдөр баталсан "Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай" хууль нь Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоож өгнө үү" гэжээ.

Иргэн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэгд гаргасан нэмэлт тайлбартаа:

Эвслийн бүлгийн үйл ажиллагаа хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд эвсэлд нэгдэж орж байсан нам ...бүлэг байгуулж болохоор заасан нь "Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд нам, эвслийн бүлэг бий болох тухай" Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчиж байгаа талаар дурджээ.

Хоёр. Нийслэлийн Байнгон дүүргийн 17 дугаар хороо, 1-13 тоотод оршин суух иргэн Б.Баяраа Үндсэн хуулийн цэцэгд гаргасан өргөдөлдөө:

1. Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд "Эвслийн бүлгийн үйл ажиллагаа хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд эвсэлд нэгдэж орж байсан нам ... бүлэг байгуулж болох"-оор заасан нь Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд нам, эвслийн бүлэг бий болох тухай Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчиж байна. Мөн энэхүү заалт нь "Эвсэл байгуулсан намууд сонгуульд болон шинээр сонгогдсон Улсын Их Хуралд нэгэн этгээд болж оролцох"-оор хуульчилсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна.

2. Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд "намын бүлэгт зөвхөн тухайн намаас нэр дэвшиж сонгогдсон гишүүд орно" гэсэн нь Улсын Их Хурлын сонгуулийн хуультай зөрчилдөж улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Уг хуулийн 2 дугаар зүйлд "Энэ хууль Улсын Их Хурлын 2004 оны 4 дэх удаагийн ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд үйлчилнэ" гэж заасан нь аливаа хууль нийгэмд тэгш, тогтвортой үйлчлэх суурь зарчмыг алдагдуулж, тодорхой хэсэг, бүлгийн ашиг сонирхлыг хамгаалж, ялгавартай хандсан байна. Тодорхой субъектэд зориулж хууль гаргасан байна гэж үзэж байна.

Иймд Улсын Их Хурлын 2005 оны 8 дугаар сарын 4-ний өдөр баталсан "Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай" хууль Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн байхыг тогтоож өгнө үү" гэжээ.

Иргэн Б.Баяра Үндсэн хуулийн цэцэгд гаргасан нэмэлт тайлбартаа:

Монгол Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно" гэж заасан бөгөөд энэ нь нам, эвслийн бүлэг зөвхөн тухайн сонгуулийн дүнд л бий болох, ийнхүү бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгох нь Үндсэн хуулийн үзэл баримтлал болохыг хуульчилсан явдал юм.

Нам, эвслийн бүлэг зөвхөн тухайн сонгуулийн үр дүнд бий болно гэдэг нь тэдгээрийн сонгогчдын өмнө хүлээх үүрэг хариуцлагатай салшгүй холбоотой. Өөрөөр хэлбэл нийт сонгогчдоос амлалт авч нам, эвслийн бүлэг байгуулан сонгогчдын саналыг авсан бол тухайн сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд өгсөн амлалтаа биелүүлэх үүднээс бүлгээр хамтарч ажиллах ёстой.

Гэтэл дээрх хууль батлагдсанаар нам, эвслийн бүлэг дуртай цагтаа тарж, эргэж байгуулагдахдаа нийт сонгогчдын өмнө ямар ч хариуцлага хүлээхгүйгээр барахгүй өөрсдийн хийсэн алдаатай бодлого, буруутай үйл ажиллагааг өмнөх дуусгавар болсон нам, эвслийн бүлэгт тохоох, ингэснээрээ нийгмийн өмнө хүлээх хариуцлагаас мултрах боломжийг бүрдүүлж байгаа юм" гэжээ.

Гурав. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл 2005 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр ирүүлсэн тайлбартаа:

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудалтай нам /эвсэл/ бүлэг байгуулж болохоор заасан боловч эвсэл цуцлагдсан тохиолдолд эвсэлд багтаж байсан 8-аас доошгүй суудалтай нам бүлэг байгуулж болох эсэх нь тодорхой бус, үүнээс шалтгаалж Улсын Их Хурлын 2004 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан "Эх орон-Ардчилал" эвсэл цуцлагдахад 8-аас дээш суудалтай Ардчилсан нам бие даасан бүлэг байгуулах бололцоогүй байсан билээ.

Энэ байдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "...Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ" гэсэн заалтыг дараах үндэслэлээр хэрэгжүүлэх замыг бүрхэг болгож байна гэж үзсэн юм.

1/ хуулийн тодорхой бус заалтаас шалтгаалан "Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь

ардчилсан төрийг төлөвшүүлэх, ард түмний хүсэл зориг, эрх ашиг, эв нэгдлийг хангах, ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулан хэрэгжүүлэх зарчимд үндэслэнэ" гэсэн заалт амьдралд хэрэгжих боломжийг хааж байна;

2/ Парламентын засаглалыг Үндсэн хуулиараа баталгаажуулсан манай орны хувьд парламентат ёсыг бэхжүүлэх нь чухал зорилт билээ. Энэ зорилтын хэрэгжилт Улсын Их Хурлын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтаас шууд хамааралтай. Эвсэл цуцлагдсан тохиолдолд намын бүлэг байгуулж болохгүй байх нөхцөл байдал нь тухайн эвсэлд багтаж байсан 8-аас доошгүй суудалтай намыг дэмжиж, саналаа өгсөн сонгогчдыг төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох боломжгүй болгож байгаа.

3/ Улс төрийн намын тухай хуулийн 22 дугаар зүйлийг бүхэлд нь зөрчиж, уг хуулийн тодорхой зарим заалт хэрэгжих боломжгүй байдал бий болсон.

Дээрх нөхцөл байдал нь иргэний төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийн үйл хэрэгт шууд оролцох эрхийг хязгаарлаж, ингэснээрээ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн "...хүнийг ялгаварлан гадуурхахыг ... хориглоно" гэсэн 10 дахь заалтыг мөн зөрчиж байгаа юм.

Ийм учраас сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийн үйл хэрэгт шууд оролцох Үндсэн хуульд заасан иргэний /сонгогчдийн/ эрхийг хангах үүднээс "Эвслийн бүлгийн үйл ажиллагаа хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд эвсэлд нэгдэн орж байсан нам Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнд 8-аас доошгүй суудал авсан бол бүлэг байгуулж болох"-ыг хуульчилсан.

2. Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт ийнхүү нэмэлт оруулахдаа "...намын бүлэгт зөвхөн тухайн намаас орж дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн нэр" гэсэн нь эвсэл цуцлагдсантай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, уг бүлэгт үйл ажиллагаа нь дуусгавар болсон эвслийн бүлэгт багтаж байсан намуудаас сонгогдсон гишүүн, бие даан нэр дэвшсэн гишүүн нэгдэн орж болохгүй гэсэн агуулгатай.

Нэгэнт намууд эвслээ цуцалсан тохиолдолд тухайн эвсэлд багтаж байсан зөвхөн 8-аас доошгүй суудалтай намд бүлэг байгуулж болох эрхийг олгож байгаа тул ийм зохицуулалт хийхээс өөр аргагүй юм. Ийм хязгаарлалт хийхгүй бол "эвсэл"-ийн дайтай бүлэг байгуулагдах нөхцөл боломж бий болно гэсэн үг юм" гэжээ.

Гурав. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр ирүүлсэн тайлбартаа:

1. Үндсэн хуулийн цэцэгд маргаан хянан шийдвэрлэх ажилгааны тухай Монгол Улсын

хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу "Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн тухай маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй" тул иргэдийн өргөлдөлд дурдсан нийм асуудлуудад тайлбар өгөх шаардлагагүй юм. Дашрамд дурдахад хууль хоорондоо зөрчигдсөн гэх үндэслэл байхгүй гэж үзэж байгаа.

2. Үндсэн хуулийн 24.1 хэсгийн зохицуулалт нь Улсын Их Хурлын дэд даргыг сонгосонтой холбогдсон болохоос бүлэг бий болгохтой холбогдолгүй юм. Сонгуулийн үр дүнд Улсын Их Хурлын бүрэн эрх эхлэхэд зохион байгуулагдсан бүлэг, Улсын Их Хурлын бүрэн эрхийн явцад бий болж болох бүлгүүдийн ялгааг салгаж ойлгох шаардлагагүй.

Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ" гэсэн заалтын дагуу Улсын Их Хурлын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 8 дугаар зүйлээрээ зохицуулан хэрэгжүүлдэг юм. Үүний дагуу Улсын Их хурал дахь нам /эвслийн/ бүлгийн талаар хуулийн зохицуулалт хийгдсэн, хийгдэж байна, мөн хийгдэх шаардлагууд бий. Эхлэл нь энэхүү хуулийн нэмэлт болж байна. Цаашид нөхөн сонгуулиар суудлын тоо 8 хүрч бүлэг байгуулах, сонгуулийн дараа эвсэл байгуулж нэгдсэн бүлэг байгуулах тухай гэх мэт. Тухайлбал, Эх орон-Ардчилал эвсэл тарсны дараа эвслийн Засгийн газраа байгуулан улс төрийн хүчнүүд нэгдсэн эвслийн бүлэг байгуулж болохгүй байсан тул нэгнийхээ бүлэгт бусад нь нэгдэж ажиллаж байсан нь ийм зохицуулалтыг шаардаж байгаа юм.

3. Үндсэн хуулийг зөрчсөн гэх бусад гомдлууд нь Улсын Их Хурлын тухай хуульд оруулсан нэмэлтийн тухай хуулийн заалтууд биш, суурь хуулийн заалтуудад холбогдох тул үүсгэсэн маргаанд хамааралгүй болно" гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурлаас 2000 онд Үндсэн хуулинд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр "Улсын Их Хурлын тухайн сонгуулийн үр дүнд бий болсон, нам, эвслийн бүлэг" гэсэн үзэл чиглэлийг Үндсэн хуулинд тусгаж өгсөн байна. Энэ үүднээс авч үзвэл Улсын Их Хурлын тухай хуульд тухайн сонгуулийн дүнг үн харгалзан намын бүлэг байгуулж болохоор оруулж буй нэмэлт нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг бүрэн агуулж байна.

2. Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Ардчилсан ёс, шударга ёс, ...тэгш байдал, ...ийг

хангах, хууль дээдлэх ёс нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсгийн "...Аль нэг нам... -ын гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно...", Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтуудыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон **ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Улсын Их Хурлаас 2005 оны 8 дугаар сарын 4-ний өдөр батлагдсан Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн "Эвслийн бүлгийн үйл ажиллагаа хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд эвсэлд нэгдэн орж байсан нам Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнд дангаараа 8-аас доошгүй суудал авсан бол бүлэг байгуулж болох бөгөөд намын бүлэгт зөвхөн тухайн намаас нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн орно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд нам, эвслийн бүлэг байгуулж болох тухай заалтыг зөрчсөн байна.

2. Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 10, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчөөгүй байна.

3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг 2005 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлснэгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын намын чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГА
ГИШҮҮД**

**Ж.БЯМБАДОРЖ
Н.ЖАНЦАН
Л.РЭНЧИН
Ж.АМАРСАНАА
Ц.САРАНТУЯА**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэлэлцэх хэсэгт хэлвэл.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 2.5

☎ 329487